



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянгол дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/002/НА-СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК</p> <p>Захирал А.Сарангэрэл Утас: 99884842 Цахим хаяг: Gereltekhburtgelaudit5@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХНХЯ	Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улванбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2010-02-25 № 156
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ
ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Б.АРИУНБОЛД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу нийслэлийн Баянгол дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Баянгол дүүргийн нийгмийн даатгалын сан нь давхардсан тоогоор нийт 6992 ажил олгогчоос авах авлагын эцсийн үлдэгдэлд 8 төрлийн арга хэмжээ авч ажилласан байна. Үүнээс 2043 ажил олгогчид сануулах арга хэмжээ авч, 357 байгууллагад улсын байцаагчийн албан шаардлага өгч, 4137 ажил олгогчийн харилцах дансны зарлагын гүйлгээг хааж, 261 ажил олгогчтой гэрээ, график байгуулж, 9 ажил олгогч иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж, 46 ажил олгогчийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр гарсан, 35 ажил олгогчийн шүүхийн шийдвэрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлж, 104 ажил олгогчийн эрэн сурвалжлах шүүхийн шийдвэр гарсан байна.

Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын мэдээллийн системийг шинэчлэх, хөгжүүлэх ажлыг "Ай Ти Зон" ХХК нь Азийн хөгжлийн банкны төслөөр нэвтрүүлж үндсэн 16 систем, туслах 45 систем, 100 гаруй модуль бүхий нэгдсэн веб суурьтай нэг мэдээллийн сан бүхий Sicos системд шилжүүлсэн бөгөөд энэхүү программаас нийгмийн даатгалын сангийн ерөнхий журнал боловсруулагдаж гарахгүй байна.

© Улаанбаатар (Ulaanbaatar) 1426050233

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	107,361,192,105.18	119,356,688,582.18
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	25,320,460,144.78	14,539,557,273.31
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	25,320,460,144.78	14,539,557,273.31
31210	Төгрөг	25,320,460,144.78	14,539,557,273.31
31213	Арилжааны банк дахь харилцах	25,320,460,144.78	14,539,557,273.31
33	АВЛАГА	82,040,731,960.40	104,817,131,308.87
33300	Татаас, санхүүжилтийн авлага	31,312,612,241.92	31,303,558,905.92
33402	Татвар, НДШ-ын авлага	50,131,084,748.55	72,964,219,764.71
33500	Бусад авлага	597,034,969.93	549,352,638.24
33510	Байгууллагаас авах авлага	255,654,489.48	77,663,039.81
33520	Хувь хүмүүсээс авах авлага	341,380,480.45	471,689,598.43
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	107,361,192,105.18	119,356,688,582.18
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,193,619,116.01	11,563,998,285.14
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,193,619,116.01	11,563,998,285.14
41300	Өглөг	2,626,827,700.16	5,744,871,378.62
41360	Бусад өглөг	2,626,827,700.16	5,744,871,378.62
41361	Байгууллагад төлөх өглөг	550,180,432.84	38,176,871.56
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,997,009,545.62	5,649,660,259.99
41366	Дансны өглөг	79,637,721.70	57,034,247.07
41400	Урьдчилж орсон орлого	3,566,791,415.85	5,819,126,906.52
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	3,566,791,415.85	5,819,126,906.52
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	101,167,572,989.17	107,792,690,297.04
51	Засгийн газрын хувь оролцоо	101,167,572,989.17	107,792,690,297.04
51200	Хуримтлагдсан үр дүн	101,167,572,989.17	107,792,690,297.04
51210	Өмнөх үеийн үр дүн	101,671,505,402.77	100,270,194,630.29
51220	Тайлант үеийн үр дүн	-503,932,413.60	7,522,495,666.75
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	107,361,192,105.18	119,356,688,582.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	901,573,516,661.71	1,040,075,484,835.39
11	ТАТВАРЫН ОРЛОГО	502,119,419,443.50	576,969,620,906.06
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	502,119,419,443.50	576,969,620,906.06
1122	Тэтгэврийн даатгалын шимтгэл	417,044,411,294.96	478,800,632,899.57
112001	Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	417,044,411,294.96	478,800,632,899.57
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	44,116,260,767.53	51,139,942,443.87
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	25,479,391,204.48	29,177,965,567.56
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	15,479,356,176.53	17,851,079,995.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	525,243,095.79	463,105,863,929.33
120	Нийтлэг татварын бус орлого	525,243,095.79	868,759,975.33
1201	Хүүгийн орлого	208,000,178.34	190,371,196.07
120002	Бусад хүүгийн орлого	208,000,178.34	190,371,196.07
120003	Торгуулийн орлого	2,752,200.00	21,058,500.00
120009	Бусад орлого	314,490,717.45	657,330,279.26
122	Тусламжийн орлого	-	462,237,103,954.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	462,237,103,954.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	129,001,645,064.00

122152	НДС-д УТ-с олгох татаасын орлого \УТ-НДС\	-	129,001,645,064.00
122004	НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого	-	333,235,458,890.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	398,928,854,122.42	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	103,570,557,592.42	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	103,570,557,592.42	-
1330	Төсвийн захирагчдаас	295,358,296,530.00	-
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	295,358,296,530.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	902,077,449,075.31	1,032,552,989,168.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	902,077,449,075.31	1,032,552,989,168.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,377,671.30	26,375,202.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,377,671.30	26,375,202.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,295,461.30	6,064,202.80
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	18,082,210.00	20,311,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	902,047,071,404.01	1,032,526,613,965.84
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	559,185,285,480.96
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	559,185,285,480.96
213104	НДС-н орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	559,185,285,480.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	410,871,782,042.21	473,341,328,484.88
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	410,871,782,042.21	473,341,328,484.88
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	491,175,289,361.80	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	491,175,289,361.80	-
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-503,932,413.60	7,522,495,666.75
VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	-503,932,413.60	7,522,495,666.75

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	984,291,716,079.05	1,121,048,044,265.84
11	ТАТВАРЫН ОРЛОГО	585,593,827,282.29	556,429,557,394.20
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	585,593,827,282.29	556,429,557,394.20
1122	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	404,521,320,938.26	461,814,242,878.90
112001	Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	404,521,320,938.26	461,814,242,878.90
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	42,783,937,396.64	49,272,858,377.37
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	34,508,839,136.19	28,194,425,357.50
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	15,413,091,854.73	17,148,030,780.43
1121	Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого	88,366,637,956.47	-
112005	Бусад эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого	88,366,637,956.47	-
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,047,608,566.76	564,618,486,871.64
120	Нийтлэг татварын бус орлого	1,047,608,566.76	102,372,329,581.64
1201	Хүүгийн орлого	209,592,656.90	190,430,857.00
120002	Бусад хүүгийн орлого	209,592,656.90	190,430,857.00
120009	Бусад орлого	838,015,909.86	102,181,898,724.64
122	Тусламжийн орлого	-	462,246,157,290.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	462,246,157,290.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	129,010,698,400.00
122152	НДС-д УТ-с олгох татаасын орлого \УТ-НДС\	-	129,010,698,400.00
122004	НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого\	-	333,235,458,890.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	397,650,280,230.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	102,291,983,700.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	102,291,983,700.00	-
1330	Төсвийн захирагчдаас	295,358,296,530.00	-
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	295,358,296,530.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	990,592,488,476.27	1,131,828,947,137.31

21	УРСГАЛ ЗАРДАЛ	990,592,488,476.27	1,131,828,947,137.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	392,499,266.02	720,387,802.14
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,377,671.30	26,375,202.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,295,461.30	6,064,202.80
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	18,082,210.00	20,311,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	362,121,594.72	694,012,599.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	362,121,594.72	694,012,599.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	990,199,989,210.25	1,131,108,559,335.17
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	661,418,557,294.41
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	661,418,557,294.41
213104	НДС-ын орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	661,418,557,294.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	409,537,614,903.75	469,690,002,040.76
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	409,537,614,903.75	469,690,002,040.76
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	580,662,374,306.50	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	580,662,374,306.50	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-6,300,772,397.22	-10,780,902,871.47
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-6,300,772,397.22	-10,780,902,871.47
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	31,621,232,542.00	25,320,460,144.78
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	25,320,460,144.78	14,539,557,273.31

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	108,929,628,751.17	108,929,628,751.17
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-7,258,123,348.40	-7,258,123,348.40
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	101,671,505,402.77	101,671,505,402.77
9	Тайлант үеийн үр дүн	-	-	-503,932,413.60	-503,932,413.60
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	101,167,572,989.17	101,167,572,989.17
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	101,167,572,989.17	101,167,572,989.17
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-897,378,358.88	-897,378,358.88
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	100,270,194,630.29	100,270,194,630.29
19	Тайлант үеийн үр дүн	-	-	7,522,495,666.75	7,522,495,666.75
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	107,792,690,297.04	107,792,690,297.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		

1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	746,163,167,200.00	686,050,042,388.60	60,113,124,811.40	91.9
11	Татварын орлого	617,152,468,800.00	557,039,343,988.60	60,113,124,811.40	90.3
112	Нийгмийн даатгалын орлого	617,152,468,800.00	557,039,343,988.60	60,113,124,811.40	90.3
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	524,812,887,700.00	462,087,201,338.95	62,725,686,361.05	88.1
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	47,019,003,400.00	49,294,367,711.98	-2,275,364,311.98	104.8
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	26,360,529,600.00	28,199,848,585.48	-1,839,318,985.48	107.0
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	18,960,048,100.00	17,457,926,352.19	1,502,121,747.81	92.1
12	Татварын бус орлого	129,010,698,400.00	129,010,698,400.00	-	100.0
122	Тусламжийн орлого	129,010,698,400.00	129,010,698,400.00	-	100.0
122001	Хандив тусламж /дотоод/	129,010,698,400.00	129,010,698,400.00	-	100.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	472,055,295,700.00	469,716,377,243.56	2,338,918,456.44	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	472,055,295,700.00	469,716,377,243.56	2,338,918,456.44	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,472,700.00	26,375,202.80	19,097,497.20	58.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,472,700.00	26,375,202.80	19,097,497.20	58.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,396,600.00	6,064,202.80	6,332,397.20	48.9
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	33,076,100.00	20,311,000.00	12,765,100.00	61.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	472,009,823,000.00	469,690,002,040.76	2,319,820,959.24	99.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	472,009,823,000.00	469,690,002,040.76	2,319,820,959.24	99.5
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	472,009,823,000.00	469,690,002,040.76	2,319,820,959.24	99.5
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	274,107,871,500.00	216,333,665,145.04	57,774,206,354.96	78.9
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	274,107,871,500.00	216,333,665,145.04	-57,774,206,354.96	78.9
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	274,107,871,500.00	216,333,665,145.04	-57,774,206,354.96	78.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	25,320,460,144.78	-25,320,460,144.78	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	14,539,557,273.31	-14,539,557,273.31	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 4¹ дүгээр зүйлийн 4^{1.1.6}-д "Нийгмийн даатгалын байгууллага" гэж нийгмийн даатгалын сан бүрдүүлж, даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зэрэг үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд" гэж тодорхойлсон.

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын сан "Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх, нийгмийн даатгалын үйлчилгээ хүргэж, 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий даатгагч болно" гэсэн эрхэм зорилгын дор 2025 онд "Нийгмийн даатгалын байгууллага нь өсөн дэвжих эрмэлзэлтэй, мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцөд түшиглэсэн үйл ажиллагаагаа цаг үргэлжид сайжруулан, түншлэл хамтын ажиллагааг дэмжин харилцан үр ашигтай хамтран ажиллаж, сайн засаглалыг хэрэгжүүлэн хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээг даатгуулагчдад хүргэнэ" гэсэн үндсэн зорилтыг дэвшүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Баянгол дүүргийн нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- МУЗГ-ын 2025 оны 65 дугаар тушаалаар "Даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход 2026 онд хэрэглэх итгэлцүүр" шинэчлэн батлагдсан;
- НДҮЗ-ийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор "Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцох журам" шинэчлэн батлагдсан;
- НДҮЗ-ийн 2025 оны 08 дугаар тогтоолоор "Мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээ" шинэчлэн батлагдсан;
- НДҮЗ-ийн 2025 оны 10 дугаар тогтоолоор "Нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээ" шинэчлэн батлагдсан;
- НДҮЗ-ийн 2025 оны 11 дүгээр тогтоолоор "Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээ" шинэчлэн батлагдсан
- НДЕГ-ын 2025 оны А/204 дүгээр тушаалаар "Маягтын загвар" шинэчлэн батлагдсан;
- НДЕГ-ын даргын 2025 оны А/281 дүгээр тушаалаар "Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэх тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, даатгуулагч, ажил олгогч, тэтгэвэр авагчийн маягтын жагсаалт"-д нэмэлт өөрчлөлт оруулсан;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянгол дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын сан нь НДЕГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/243 дугаар тушаалаар баталсан НБББББ-ийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянгол дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,995,496.5 мянган төгрөгөөр буюу 10.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	25,320,460.1	14,539,557.2	-10,780,902.9
Авлага	82,040,732.0	104,817,131.4	22,776,399.4
Нийт хөрөнгийн дүн	107,361,192.1	119,356,688.6	11,995,496.5
Өр төлбөр	2,626,827.8	5,744,871.4	3,118,043.6
Урьдчилж орсон орлого	3,566,791.4	5,819,127.0	2,252,335.6
Хуримтлагдсан үр дүн	101,167,572.9	107,792,690.2	6,625,117.3
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн/	107,361,192.1	119,356,688.6	11,995,496.5

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, өр төлбөр, урьдчилж орсон орлого данс байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 14,539,557.2 мянган төгрөг болж, 10,780,902.9 мянган төгрөгөөр буурсан нь тэтгэвэр, тэтгэмжийн дараа сарын олголтын санхүүжилтийн үлдэгдэлтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 104,817,131.4 мянган төгрөг болж, 22,776,399.4 мянган төгрөгөөр өссөн нь ажил олгогч байгууллагуудаас авах нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 22,833,135.1 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 130,309.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, улсын төсвөөс авах татаас санхүүжилтийн авлага 9,053.3 мянган төгрөг, байгууллагаас авах авлага 177,991.4 мянган төгрөгөөр буурснаас тус тус шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэлд ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагуудаас авах НДШ-ийн 81,497,217.8 мянган төгрөг, ажил олгогч, тэтгэвэр, тэтгэмж авагч нартай холбоотой зөрчилд улсын байцаагчаас тогтоосон акт, алдангийн болон тооцоо нийлж баталгаажуулсан авлагын үлдэгдлийн 549,352.6 мянган төгрөг, Засгийн газрын 2022 оны тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, бүртгэх, тайлагнах, хяналт тавих журам”-тай холбоотой улсын төсвөөс авах татаас санхүүжилтийн 31,303,558.9 мянган төгрөг, нийт 104,817,131.3 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага дансанд нийт 4028 ажил олгогчоос авах 1 жилийн насжилттай 50,932,420.3 мянган төгрөг, 28 ажил олгогчоос авах 2-3 жилийн насжилттай 21,052,718.4 мянган төгрөг, 4-5 насжилттай 439 ажил олгогчоос авах 8,749,381.1 мянган төгрөг, 5-аас дээш жилийн насжилттай 1084 ажил олгогчоос авах 5,709,970.4 мянган төгрөг, нийт 6465 ажил олгогчоос авах 86,444,490.2 мянган төгрөгийн авлагатай байна.

Нийт 2043 ажил олгогчид сануулах арга хэмжээ авч, 357 байгууллагад улсын байцаагчийн албан шаардлага өгч, 4137 ажил олгогчийн харилцах дансны зарлагын гүйлгээг хааж, 261 ажил олгогчтой гэрээ, график байгуулж, 9 ажил олгогч иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан, 46 ажил олгогч иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр гарсан, 35 ажил олгогчийн шүүхийн шийдвэрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлж, 104 ажил олгогчийн эрэн сурвалжлах шүүхийн шийдвэр гарсан давхардсан тоогоор нийт 6992 ажил олгогчид 8 төрлийн 6992 арга хэмжээ авч ажилласан байна.

Өглөг дансны үлдэгдэл 5,744,871.4 мянган төгрөг болж, 3,118,043.6 мянган төгрөгөөр өссөн нь ажилгүйдлийн даатгалын сангаас даатгуулагчдад олгох өглөг өссөнөөс шалтгаалжээ.

Өглөгийн дансны эцсийн үлдэгдэлд ажилгүйдлийн даатгалын сангаас 2340 даатгуулагчдад олгох ажилгүйдлийн тэтгэмжийн 4,169,320.2 мянган төгрөг, тэтгэвэр тэтгэмжийн сангаас тэтгэвэр авагч нарт олгох 1,480,340.1 мянган төгрөг, байгууллага, хувь хүмүүст буцаан олгох шимтгэлийн 95,211.0 мянган төгрөг, нийт мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 5,819,127.0 мянган төгрөг болж, 2,252,335.6 мянган төгрөгөөр өссөн нь ажил олгогч болон даатгуулагчийн урьдчилж төлсөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт өссөнөөс шалтгаалсан байна.

Урьдчилж орсон орлого дансны эцсийн үлдэгдэлд 3213 ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагын илүү төлсөн шимтгэлийн 3,344,747.4 мянган төгрөг, сайн дурын даатгуулагч, малчин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ харж буй эцэг, эхийн урьдчилж төлсөн 2,474,379.5 мянган төгрөг, нийт 5,819,126.9 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.

Урьдчилж орсон орлого дансны эцсийн үлдэгдэлд 3213 ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагын илүү төлсөн шимтгэлийн 3,344,747.4 мянган төгрөг, 1 жилийн насжилттай 2236 ажил олгогчид өгөх 3,076,897.6 мянган төгрөг, 2-3 жилийн насжилттай 797 ажил олгогчид өгөх 158,930.6 мянган төгрөг, 4-5 жилийн насжилттай 104 ажил олгогчид өгөх 15,424.4 мянган төгрөг, 5-аас дээш жилийн насжилттай 76 ажил олгогчид өгөх 93,494.6 мянган төгрөг, нийт 3213 ажил олгогчид өгөх 3,344,747.4 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 134,501,968.2 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 130,475,540.1 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардал байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Баянгол дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 126,482,836.7 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 619,312,158.3 мянган төгрөг, нийт зарлагыг 462,591,533.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 9,463,762.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 472,055,295.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвийн санхүүжилтийг 2,527,861.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 129,010,698.4 мянган төгрөгөөр тодотгож, үйл ажиллагааны орлогыг 2,159,689.5 мянган төгрөгөөр бууруулж, 617,152,468.8 мянган төгрөгөөр тодотгож, тус тус баталсан байна.

Тайлант 2025 онд НДЕГ-ын даргын 2023 оны “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1-т заасны дагуу тус сангаас 661,418,557.2 мянган төгрөгийг НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд төвлөрүүлж, мөн журмын 4 дүгээр зүйлийн 4.1-д заасны дагуу НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах данснаас тус санд төсвийн хуваарийг үндэслэн улсын төсвийн санхүүжилт 129,010,698.4 мянган төгрөг, санхүүжилтийн орлого 333,235,458.8 мянган төгрөг, нийт 462,246,157.2 мянган төгрөгийг хуваарилж, санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 469,716,377.2 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь тэтгэвэр, ҮОМШӨ-ний сангийн 2,338,918.4 мянган төгрөгийн олголтыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
2	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	472,009,823.0	469,690,002.0	2,319,820.9	99.5
2.1	Тэтгэврийн даатгалын шимтгэл	425,930,532.1	421,756,301.9	4,174,230.2	99.02
2.2	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	24,167,450.4	26,077,710.8	-1,910,260.4	107.9
2.3	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,298,197.8	2,712,752.3	585,445.5	82.2
2.4	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	18,613,642.7	19,143,237.0	-529,594.31	102.8
3	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,472.7	26,375.2	19,097.5	58.0
3.1	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,396.6	6,064.2	6,332.4	48.9
3.2	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	33,076.1	20,311.0	12,765.1	61.4
	Нийт дүн	472,055,295.7	469,716,377.2	2,338,918.4	99.5

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын сан нь 2025 онд баталсан төлөвлөгөөгөөр 617,152,468.8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 557,039,343.9 мянган төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөнөөс 60,113,124.8 мянган төгрөгөөр дутуу буюу 90.2 хувиар төлөвлөгөө биелсэн байна.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангийн төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэврийн сан	524,812,887.7	462,087,201.3	62,725,686.3	88.1
Тэтгэмжийн сан	47,019,003.4	49,294,367.7	-2,275,364.3	104.8
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн даатгалын сан	26,360,529.6	28,199,848.6	-1,839,318.9	106.9
Ажилгүйдлийн даатгалын сан	18,960,048.1	17,457,926.3	1,502,121.7	92.1
Нийт дүн	617,152,468.8	557,039,343.9	60,113,124.8	90.2

Хүснэгт 4. Улсын төсвийн санхүүжилтийн орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэврийн даатгалын сан	128,628,882.0	128,628,882.0	-	100.0
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн даатгалын сан	381,816.4	381,816.4	-	100.0
Нийт дүн	129,010,698.4	129,010,698.4	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансанд тайлант онд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус санд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Засгийн газрын төвлөрсөн сангийн хувьд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайлан хамааралгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын сан нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн сангийн үйл ажиллагааг сайжруулахаар ажил олгогчоос авах авлагыг барагдуулах болон он дамжсан илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох арга хэмжээг тус тус авч хэрэгжүүлэх, Нийгмийн даатгалын багц хуулийг ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-эрдэнэ, туслах аудитор Э.Алтангэрэл, Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, дараагийн шатны чанарын хяналтыг Нийслэл дэх Төрийн аудитын газрын аудитын менежер Я.Алтанцэцэг, ахлах менежер Х.Түвшинбаяр, газрын дарга, Тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянгол дүүргийн нийгмийн даатгалын сан нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 60 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын дансыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны нийт зардлын 902,077,449.1 мянган мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,020,774.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн захирагч нь хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 72 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баянгол дүүргийн нийгмийн даатгалын сан нь 2025 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 2,770,229,741.5 мянган төгрөгийн 16062 мэдээллийг ил тод байршуулахаас 2,770,229,741.5 мянган төгрөгийн 16062 мэдээллийг ил тод мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг аудитад хамруулж 76,716,710.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 73,198,709.6 мянган төгрөгийн 2 алдааг залруулах, зөрчлийг арилгах 3,518,001.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар давтан үнэлэхэд 73,198,709.6 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 3,518,001.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгаж, аудитын шийдвэрийг хэрэгжүүлсэн байна.

4.5.2 Өмнөх шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд түүврийн аргаар шалгалт хийж, шалгалтаар тогтоосон 161,688.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгаж, өр төлбөрийг барагдуулах 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх шалгалтын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	161,688.6	1	161,688.6	100.0
Нийт дүн	1	161,688.6	1	161,688.6	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2 зөрчил¹ илэрсэнд 2 зөвлөмж өгсөн байна.

Нийт илрүүлсэн 525,466.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт-1: Нийт 47 идэвхитэй ажил олгогч байгууллагаас авах нийгмийн даатгалын шимтгэлийн 1 жилийн насжилттай нийт 475,564.2 мянган төгрөгийн, авлагын үлдэгдлийг барагдуулах дараагийн шатны арга хэмжээ авагдаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,,," , мөн хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.5-д "Нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 6.1-д заасан ажил олгогчийн шимтгэлийн өрийг 6.4-т заасан хугацаанаас хойш төлөгдөөгүй хугацаагаар нь дараах байдлаар ангилна", 6.6-д "Нийгмийн даатгалын шимтгэлийг өрийг барагдуулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Идэвхитэй ажил олгогчоос авах авлагыг барагдуулах дараагийн шатны арга хэмжээ авч хэрэгжүүлэх зөвлөмж өгөв.

Илрүүлэлт-2: Нийт 20 идэвхигүй ажил олгогч байгууллагын илүү төлсөн шимтгэлийн 49,902.4 мянган төгрөгийн, 2 жилийн насжилттай өглөгийн үлдэгдлийг буцаан олгох арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,,," , мөн хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Идэвхигүй ажил олгогчийн он дамжсан, илүү төлсөн шимтгэлийн өглөгийг буцаан олгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Идэвхитэй ажил олгогчийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй	1	475,564.2	-	-	-	-	1	475,564.2	-	-	-	-
Идэвхигүй ажил олгогчийн он дамжсан, илүү төлсөн шимтгэлийн өглөгийг барагдуулах арга хэмжээ аваагүй	1	49,902.4	-	-	-	-	1	49,902.4	-	-	-	-
Дүн	2	525,466.6					2	525,466.6		-	-	-